

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН

2021.06.11

Тус хэлтэс нь хууль зүйн салбарын бодлого, зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт зорилго, арга хэмжээ, "Орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих жил"-д зориулан иргэдийн оролцоог дэмжиж соён гэгээрүүлэх, хууль, эрх зүйн туслалцаа, үйлчилгээг иргэд, олон нийт, албан тушаалтан, албан байгууллагад хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, эрх зүйн зөвлөгөө мэдээллээр хангахын зэрэгцээ хэлтэс, агентлагийн удирдлагууд, сумдын Засаг дарга, сумдад бэлтгэгдсэн "Эрх зүйн хөтөч"-үүд, сумдын орон тооны бус "Эрх зүйн хөтөч" багийн ахлагч буюу сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Ерөнхий боловсролын сургуулийн Насан туршийн боловсролын багш нар болон бусад холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг хууль тогтоомж хэрэгжүүлэх, сурталчлах ажилд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж, тэднээс гаргасан санал хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэн хариу өгөх, цаашид хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын болон хэлтсийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2021 оны эхний хагас жилд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн сан бүрдүүлэлт,
бүртгэн цэгцлэх ажлын гүйцэтгэл, иргэд, аж ахуйн нэгжид
цахим болон гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн талаар

Тус хугацаанд эрх зүйн мэдээллийн өөрчлөлт хөдөлгөөний бүртгэлийн нэгдсэн санд нийт 154 эрх зүйн актыг бүртгэсэн ба үүнээс шинээр 19, нэмэлт, өөрчлөлт орсон 66 хууль, Засгийн газрын тогтоол 30, УИХ-ын тогтоол 32, Үндсэн хуулийн цэцийн тогтоол 3, Ерөнхийлөгчийн зарлиг 4-ийг тус тус бүртгэн санг баяжуулж, өдөр тутмын болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах үйл ажиллагаанд ашиглаж байна.

Хүчингүй болгосон, зүйл заалт хассан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт давхардсан тоогоор 16 хууль, тогтоомжид тухай бүр эрх зүйн ангилал хийж, тамга тэмдэг дарж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цахим болон гар сангаас лавлагаа мэдээллийг 105 иргэн, албан тушаалтанд үзүүлж үйлчилгээг хүргэлээ.

Аймгийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг
хянаж санал дүгнэлт өгөх, тухайн жилд гаргасан захиргааны
хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг зохих журмын дагуу
хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны
төв байгууллагад хянуулж, бүртгүүлсэн талаар

Тус хугацаанд аймгийн Засаг даргаас батлан гаргасан 146 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж, төслийн шатанд захирамж боловсруулсан этгээдээр санал авах хуудас болон хяналтын дагалдах хуудсыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга болон хэлтсийн дарга нараар хянуулж санал авах ажлыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 197 захирамжийг аймгийн www.dundgovi.gov.mn вэб сайтын эрх зүйн актууд цэсний Засаг даргын захирамжууд хэсэгт байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, зарим шийдвэрийг байгууллага, иргэдэд хуулбар хувиар хүргүүлэн ажиллалаа.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Луус, Өлзийт сумдын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын батлан гаргасан "Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай" 2 эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

Сумын Засаг даргын шийдвэр хууль тогтоомжид нийцэж
буй эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг
арилгуулах талаар авсан арга хэмжээ

Тус хугацаанд сумдын Засаг дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хянах хуваарийг батлан хүргүүлж, уг хуваарийн дагуу хянах, зөвлөмж хүргүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллалаа.


2021 онд сумдын Засаг дарга нарын батлан гаргасан 444 эрх зүйн акт, сумдын төрийн байгууллагуудын дарга нараас батлан гаргасан 335 эрх зүйн актын хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж хүргүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нараас батлан гаргасан 337 тушаалыг хуваарийн дагуу хянаж, нийт 482 эрх зүйн актад гаргасан зөрчлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын чанар, үр дүн, шинээр боловсруулж
буй хууль тогтоомжийн төслийн талаар хэлэлцүүлэг
зохион байгуулж, санал авсан талаар



Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд халдварт цар тахалтай холбогдуулан сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр эхний хагас жилд эрх зүйн сургалтыг 6 удаа 217, сурталчилгааг 2 удаа 250 иргэд, албан хаагчдыг тус тус оролцуулан зохион байгуулж нийт 467 иргэд, албан хаагчдыг оролцуулж, зөвлөгөө, лавлагаа, баримт бичиг боловсруулах чиглэлээр 105 иргэн, албан хаагчдад эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүллээ. Эрх зүйн албан ба албан бус сургалтыг сум, байгууллагуудын удирдлагууд, Эрх зүйн хөтөч нараар дамжуулан иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох 3 сарын аян зохион байгуулах, тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд хамтран ажиллаж семинар, сургалтыг цахим хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

➤ Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс нээсэн “Эрх зүйн хөтөч нэгдсэн групп”, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс нээсэн “Дундговь Эрх зүйн хөтөч пэйж хуудас”, “Дундговь Эрх зүйн хөтөч” чат зэрэг цахим хуудсуудаар сумдад бэлтгэсэн Эрх зүйн хөтөч нарыг цахим хэлбэрээр арга зүйн удирдлага, мэдээллээр ханган, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажиллалаа.

➤ Эрх зүйн хөтчийн нэгдсэн группт аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүд нэгдэж тус группт тавигдсан хууль, эрх зүйн сурталчилгааны мэдээ, мэдээлэл, 1800-1202 подкастын цуврал дугааруудыг тухай бүрт Эрх зүйн хөтөчүүд шэйрлэж нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Дундговь “Эрх зүйн хөтөч”



нь
олон



группээр Гэр бүл гэж юу вэ, Хүүхдийн тэтгэлэгийн ажиллагаа харандааны адал явдал, Мэдээллийн ил тод байдал, Ахмад настны тухай, Ан амьтны тухай, Байгаль орчны, Эрүүл мэндийн, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай,

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Хүүхэд хамгаалах тухай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, Малын хулгайтай тэмцэх, Ойн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай зэрэг 14 хууль тогтоомжоор бэлтгэсэн шторкийг цувралаар олон нийтэд хүргэж байна.

➤ “Бүх нийтийн эрх үндэсний хөтөлбөр”-ийг шатны буюу 2020-2023 батлуулсан тул улсын боловсролын үндэсний эрх зүйн боловсролыг хэрэгжүүлэх арга батлагдаж ирмэгц сумын хийж хэрэгжүүлэх арга Засаг даргын Тамгын



хугацаанд сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга буюу “Эрх зүйн хөтөч” орон тооны бус багийн ахлагч нарт “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллах, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, эрх зүйн албан бус цахим сургалтыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр сургалт, сурталчилгаа хүргэх, бэлтгэгдсэн эрх зүйн хөтөчүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, тэднийг дэмжиж хамтран ажиллах талаарх семинар, сургалтыг танхимаар зохион байгууллаа. Энэ үеэр аймагт ажиллаж буй өмгөөлөгчид болон сумдын “Эрх зүйн хөтөч нарын дэлгэрэнгүй танилцуулгыг 300 ш, иргэдэд нэн шаардлагатай хууль тогтоомжоор 300 ш гарын авлагыг тус тус бэлтгэн сумдад нийт 600 ширхэгийг иргэдэд хүргүүлэхээр түгээсэн.

➤ Эрх зүйн хөтөч орон тооны бус нарын үйл ажиллагааг эрчимжүүлэх Тамгын газрын албан хаагчдаас 2021 эрх зүйн актын хөтөлбөрийн хууль тогтоомжоор зохион боловсруулан хүргүүлж, хяналт тавин, хамтран ажиллалаа.

➤ “Орон нутгийн хөгжилд

жил”-д зориулан “Бүх нийтийн эрх зүйн цахим хэлбэрээр дээшлүүлэх нь” 3 сарын аяныг өдрөөс эхлэн аймаг, сумын хэмжээнд зохион иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн цахим болон цахим бус байдлаар нээлттэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр бүх нийтийн эрх тасралтгүй дээшлүүлэхээр 11 төрлийн үйл зохион байгуулан, 4 төрлийн үр дүнд хүрэх ажиллаж, энэ хугацаанд сумдад бэлтгэгдсэн “Эрх чадавхжуулах эрх зүйн албан бус сургалтыг зохион байгуулж, хууль, эрх зүйн сурталчилгаануудыг иргэд, олон нийтэд цувралаар хүргэн ажиллалаа.

зүйн боловсролыг дээшлүүлэх хэрэгжүүлэх арга хэмжээний II оны аймгийн төлөвлөгөөг 2020 онд буюу Бүх нийтийн эрх зүйн зөвлөлөөс батлагдсан “Бүх нийтийн дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэмжээний 2021 оны төлөвлөгөөг ЗДТГ-ыг төлөвлөгөөндөө тодотгол зүйн зөвлөгөө, зөвлөмжийг сумдын газрын дарга нарт хүргүүллээ. Тус

ЭРДЭНЭДАЛАЙ СУМДАД БЭЛТГЭГДСЭН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧҮҮД


№	Огноо	Нэр	Ажил хувиар	Утасны
1	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
2	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
3	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
4	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
5	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024

АЙМАГ ДАХЬ ӨМГӨӨЛӨГЧ НАРЫН МЭДЭЭЛЭЛ

№	Огноо	Нэр	Ажил хувиар	Утасны
1	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
2	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
3	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
4	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024
5	08/08/2021	Сайтсангийн Сүхбаатар	Сайтсангийн Сүхбаатар	09110024

WWW.KHUTCH.MN ЦАХИМ ХУУДАС АЖИЛЛУУЛАХ ИРГЭНД


ЭРХ ЗҮЙН ХӨТӨЧ НАРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГЫГ 300 Ш, ИРГЭДЭД НЭН ШААРДЛАГАТАЙ ХУУЛЬ ТОГТООМЖООР 300 Ш ГАРЫН АВЛАГЫГ ТУС ТУС БЭЛТГЭН СУМДАД НИЙТ 600 ШИРХЭГИЙГ ИРГЭДЭД ХҮРГҮҮЛЭХЭЭР ТҮГЭЭСЭН.



баг болон “Эрх зүйн хөтөч” зорилгоор сумын Засаг даргын онд судлан сурталчлах, хууль, жагсаалтыг улирал бүр 4-5 байгуулуулахаар жагсаалтыг цахим хэлбэрээр сурталчилж

иргэдийн оролцоог дэмжих

боловсролыг 04 дүгээр 14-ний байгуулан мэдээ, мэдлэгийг хүртээмжтэй, зүйн боловсролыг ажиллагааг зорилго тавин зүйн хөтөч”-үүдээ хууль, эрх зүйн



➤ Халдварт цар “Эрх зүйн хөтөч”-үүдийг зүйн албан бус сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх бүртгэлийн хэлтэс, Хүний дахь референт, Нийгмийн даатгалын хэлтэс, үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар,



Татварын хэлтэс, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, аймгийн Насан туршийн боловсролын төв зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран 60 эрх зүйн хөтөчүүдэд нэг өдрийн эрх зүйн сургалтыг амжилттай зохион байгуулж, “Эрх зүйн хөтөч”-үүд бүрэн хамрагдаж цахим сургалтыг үр дүнтэй боллоо гэж үнэлсэн.


Сумдын “Эрх зүйн хөтөч”-үүд 2 дах жилдээ ажиллаж байгаа бөгөөд зохион байгуулсан үйл ажиллагааг “Эрх зүйн хөтөч”-ийн ажлыг дүгнэх батлагдсан шалгуур үзүүлэлтээр хагас, бүтэн жилээр сумын ЗДТГ-ын дарга нар үнэлж дүгнэх ажлыг хийж байна.

➤ “Хуульчийн ПРО-БОНО өдөр-2021” арга 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн төвийн өмгөөлөгч болон аймгийн өмгөөлөгчдийн өмгөөлөгчидтэй хамтран утсаар, цахимаар иргэдэд төлбөргүй зөвлөгөө, үйлчилгээг 51 иргэнд үзүүлж, ажиллагааг зохион байгуулав.




хэмжээний хүрээнд туслалцааны зөвлөлийн Хууль зүйн үнэ сурталчилгаат үйл

➤ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос Цар тахлын үеийн шийдвэр гаргалт ба хүний эрх цахим хэлэлцүүлэгийг аймгийн удирдах албан тушаалтнуудад зохион байгуулж, оролцсон албан тушаалтнууд тулгарч буй зарим асуудлыг тодруулан нэг ойлголттой болж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



➤ Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой бэлтгэсэн Надад Цогоо, Ариун эрхэм нандин, Дуудлага, Хүү, хөрш зэрэг 6 ширхэг богино хэмжээний киног www.dundgovi.gov.mn вэбсайт, “Дундговь Засаг даргын Тамгын газар”, “Эрх зүйн хөтөч” хуудас, сум, байгууллагуудын вэбсайт болон хуудас, аймгийн төвд байрлаж буй ЛЕД улирлаар сурталчлан таниуллаа.



бэлтгэн

итгэ, Гэнэн Чимээгүй

аймгийн пэйж пэйж дэлгэцээр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйл буюу аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд 2021 онд 145.0 сая төгрөг батлуулж, хууль сахиулах байгууллагуудын саналд үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөг тус зөвлөлийн

нэгдүгээр хурлаар хэлэлцэн, 3 бүлэг 44 заалттайгаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ оны эхний 5 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд 38.496.300 төгрөг зарцууллаа. Тухайлбал аймгийн Засаг даргын тамгын газраас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, хорио цээрийн дэглэм тогтоох хяналтын цэгт ажиллаж байгаа алба хаагчдын ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор 20.000.000 төгрөгний явуулын пост, 6.537.500 төгрөгний хамгаалалтын хаалтыг тус тус шийдвэрлүүлсэн.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас улсын чанартай зам дагуух 3 суманд согтуурал хэмжих багажаар хангаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангах ажилд 450.000 төгрөгний үнэ бүхий микрофон олголоо.

Хүүхдээс мэдүүлэг авах өрөөний зураг төслийг стандартын дагуу гаргаж аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хандан 9.024.700 төгрөгийг шийдвэрлүүлэн засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг эхлүүлээд байна.

Аймгийн хэмжээний гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралтын талаарх мэдээллийг нэгдсэн сангаас сар бүрээр гарган, нөхцөл байдалд дүгнэлт судалгаа хийж, аймаг, сумдын Засаг дарга нар, ГХУСАЗЗөвлөлүүдэд нийт 56 удаа танилцуулга мэдээлэлд 149 санал хүргүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулан ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй “Хайртай бүхнээ хамгаалъя” арга хэмжээний хүрээнд иргэд малчдын унаа болсон мотоциклын ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүмүүн бид нэг л амьтай” 8 минутын зохиомжийг бэлтгэн 1.005.470 иргэнд хүргэсэн.

Мөн орон нутгийн замд хурд хэтрүүлсний улмаас үйлдэгддэг ослыг бууруулах зорилгоор 2 төрлийн видео сэрэмжлүүлэг бэлтгэж сум, байгууллагын цахим хуудсанд байршуулснаар 502 лайк, 158 түгээлт, 181.704 иргэнд хүргэж, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмээр 2 төрлийн зурагт хуудас хийж орон нутгийн хамгийн олон дагагчтай зарын группд түгээсэн.

“Эх орон газар шороогоо хамгаалъя” 5 минутын видео зохиомжийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2. /Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох/, 24.5. /Хууль бусаар ан ангнах/, 24.6. /Хууль бусаар мод бэлтгэх/ дахь хэсгээр видео контент бэлтгэж цахим орчинд сурталчилсан.

Цагдаагийн газраас “Хорио цээр”, “Бүрэн бус тээврийн хэрэгсэл”, “Хулгайн тээвэр”, “Аз жаргалтай дурсамж”, “Хамтарсан багаараа хамгаалъя”, “Өсвөрийн сэргийлэгч”, “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх өдөр”, “Дотуур байр”, “Шаг”, “Эмзэг цэг” зэрэг 10 удаагийн хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулсан байна.

“Дундговийн амьдрал” сонинд 1, урсдаг самбарт 4, Аюулаас сэргийлэх FM-107.5-аар 2 удаа мэдээлэл хийж, орон нутгийн олон дагагчтай зарын группүүдээр сурталчилсан.

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газартай хамтарч “Хамтарсан багаараа хамгаалъя” аяныг зохион байгуулан аяны хүрээнд ахуйн хүрээнд архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй 15 айл өрхөөр орж урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, 3 төрлийн санамж сэрэмжлүүлэг тарааж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт хувийн хэрэг нээн хариуцсан багийн хэсгийн байцаагч нарт хуваарилан биечилсэн хяналт тавин ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Үе тэнгийнхний дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх”, “Архи, тамхины хор нөлөө”, “Цахим

орчны зохистой хэрэглээ” зэрэг сэдвээр МСҮТ-ийн 54 оюутан, ерөнхий боловсролын сургуулийн 101 сурагчдад сургалт мэдээлэл хийсэн.

Эдгээр зохион байгуулсан ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 2021 оны эхний 5 сард бүртгэгдсэн гэмт хэрэг 16.9 хувь, хүчиндэх гэмт хэрэг 100 хувь, дээрэм 50 хувь, хулгайлах гэмт хэрэг 57.1 хувь, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 45.4 хувь, бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэрэг 9 хувь, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 25 хувь, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 26.6 хувь, гэмт хэргийн улмаас хохирсон хүн 20.9 хувь, нийт зөрчил 41.1, эрүүлжүүлэгдсэн хүн 60.9 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлтэй гарав.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр

Нийтээр тэмдэглэх баяр амралтын өдрүүд, коронавирус (ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах аж ахуй нэгжүүдэд цагийн хязгаар тогтоох, архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглох зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах шийдвэр гаргуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж энэ оны эхний хагас жилд нийт 29 захирамж шийдвэрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 53 аж ахуйн нэгжид албан мэдэгдэл хүргүүлж, нийт 17860 шил архи, 13837 шил пиво, 1864 шил дарсыг агуулахад хийж лацдуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/17 дугаар захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааг тус өдрөөс эхлэн архи согтууруулах ундаа худалдан борлуулж үйлчлэхийг зөвшөөрсөнтэй холбогдуулан Цагдаагийн газраас аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдийн агуулахад лацадсан архинд хяналтын тооллого хийхэд зөрчил илрээгүй.

Гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулсан 17 иргэний зөрчлийг илрүүлж 85 шил архи, согтууруулах ундааг хурааж 850.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.3.1.1-д заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого” боловсруулах ажлыг эхлүүлэн иргэд, олон нийт, төрийн албан хаагчдаас санал авах ажлыг зохион байгуулж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаарх бодлого, шийдвэрийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, архивын тасгаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, архивын сан хөмрөгийн хадгалалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах чиглэлээр хийсэн ажлын талаар

Тус аймгийн ЗДТГ-ын Архивын тасаг нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль Монгол Улсын хууль, тогтоомж, Засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр болон Архивын Ерөнхий газраас өгсөн зөвлөмж, чиглэл, Төрийн архивын ажлын зааврын дагуу 2021 оны эхний хагас жилд дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт
баримтын нягтлан шалгалт

Тус аймгийн архиваас 2021 онд нөхөн бүрдүүлэлт хийх 13 сум, байгууллагын жагсаалт графикайг гаргаж, холбогдох 4 хөмрөгийн үүсгэгчийн 238 хадгаламжийн нэгжийг төрийн архивт хүлээн авч архивт баримт хүлээн авсан бүртгэл, актыг зааврын дагуу хөтлөж архивын сан хөмрөгөөр ангилан төрөлжүүлж хөмрөгт байрлуулсан.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу 4 шинээр ашиглалтанд оруулсан болон барилгын засвар, өргөтгөлийн үйл ажиллагаанд улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, 15 зураг төсөл техник технологийн цаасан болон тусгай төрлийн баримтаар архивт нөхөн бүрдүүлэлт хийж, 41 хадгаламжийн нэгжийг зохих журмын дагуу хүлээн авч акт, жагсаалтыг үйлдэж байрлуулав.

Аймгийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг 2 удаа хуралдуулж аймгийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх байгууллагын жагсаалт, хуваарь болон сум, байгууллагын байнга хадгалах баримтын данс, бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, хадгалах хугацаа дууссан баримтын устгах хэргийн акт зэрэг нийт 10 сум, байгууллагуудын бүртгэл жагсаалтыг хянан хэлэлцэж хариуг холбогдох сум, байгууллагад хүргүүлэв.

Засгийн газрын тогтоолын дагуу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг цахимаар хүлээн авах ажлыг зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд 3 байгууллага, 9 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох лавлагааг тоон гарын үсгээр гаргаж хүргүүлсэн.

Баримтын хадгалалт хамгаалалт:

Төрийн архивын баримт бичгийн хадгалалт хамгаалалтын горимыг заавар дүрмийн дагуу хийж гүйцэтгэж, Төрийн архивын 2 хадгаламжийн сангийн 90 мкв талбайд шавьжгүйтгэлийн ариутгалыг 2 удаа хийлгэлээ.

Хөмрөг үүсгэгч 15 байгууллагын баримт бичигт дансаар хэсэгчилсэн тооллого явуулж, тооллого явуулсан тухай акт үйлдэн хэрэгт баяжилт хийж, зөрүүтэй данс бүртгэлийг өөрчлөн шинэчилсэн. Цахимд орохгүй Арбитр 34, БЗТТовчоо 58, УЗНЗөвлөл 62, МЗНН 65, Эмэгтэйчүүдийн зөвлөл 72, Шүүх 75, Ахмадын хороо 77, ЯБЗөвлөл 86, БХТН 92, ИБТАлба 93, ССМАлба 94, Нотариатын салбар 97, Хадгаламж банк 102, Дэлхийн зөн ОНХХ 109, БЗТовчоо 87 буюу 14 хөмрөгийн дансыг шинэчилж, 8 хөмрөгийн дансыг шинээр үйлдэв. Мөн Нэгдсэн эмнэлэг, ХХААГ, Боловсрол, Татвар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг 5 хөмрөгийн дансыг шинэчлэн дахин боловсруулав.

Тооллогын мөрөөр 150 ширхэг хайрцаг захиалан авч 11 хөмрөгийн 14 дансны 1956 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын хайрцагт хийж, заагуурыг шинэчлэв.

Төрийн архивын баримт бичгийг цахимжуулах ажлын хүрээнд 13 хөмрөгийн 13 дансны 265 хадгалмжийн нэгжийн 17154 хуудас баримтыг цахим санд оруулаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгууль болсонтой холбогдуулан 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар битүүмжилсэн 71 ширхэг саналын хуудсыг хүлээж аваад байна.

Баримт ашиглалтын талаар:

Үндэсний архивын Газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж архивын баримтыг ашиглуулах зорилгоор иргэд, байгууллагын нийгэм эрх зүйн шинж чанартай лавлагаа олгох ажлыг хийж гүйцэтгэснээр эхний хагас жилийн байдлаар нийт 503 иргэний хүсэлтийг хүлээн авч 137 иргэнд лавлагаа, 366 иргэнд хувь хуулбар гарган өгч, нийт 500 гаруй лавлагаа, хуулбар гаргаж үйлчилсэн. Эдгээр лавлагаанд давхардсан тоогоор 2700 гаруй хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагааны ажилд ашиглууллаа.

Уншлагын танхимаар үйлчлүүлсэн 5 иргэнд 72 хадгаламжийн нэгжийг судалгаанд ашиглуулсан.

Мэргэжил арга зүйн ажлын талаар:

МУ-ын Засгийн газрын 2000 оны 86 дугаар тогтоолын дагуу Архивын Ерөнхий газрын дэргэдэх мэргэжил олгох, дээшлүүлэх, давтан сургах сургалтын төвд суралцуулах 31 ажилтны захиалгыг сум, байгууллагуудаас авч Архивын Ерөнхий газарт хүргүүлсэн. Тус газраас анхан болон мэргэшүүлэхийн сургалтыг цахимаар зохион байгуулж явууллаа. Анхан шатны сургалтанд 5, мэргэшүүлэх сургалтанд 7 албан хаагч хамрагдсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоол, Зохион байгуулалт, баримт бичгийн стандартаар сургалт зохион байгуулж нийт 22 төрийн байгууллагын 261 төрийн албан хаагчийг хамруулаад байна. Шинэчлэн батлагдсан эрх зүйн актуудыг сурталчлах, хэрэгжүүлэх үүднээс “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан дүрэм, журмыг сурталчлан таниулах” 3 сарын аяныг 2021 оны 02 дугаар сарын 16-наас 05 дугаар сарын 16-ыг хүртэлх хугацаанд сум, байгууллагын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.



Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Сумдын удирдах ажилтан, албан хаагчдын зөвлөлдөх уулзалт, сургалт-2021” арга хэмжээнд “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх хууль тогтоомж”-ийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал сэдвийн хүрээнд сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх тухай” заавар болон Стандарт хэмжил зүйн Үндэсний төвийн Зөвлөлийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичгийн стандартын дагуу хэвлэмэл хуудсыг шинээр хэвлүүлэх ажилд хяналт тавьж ажилласнаар нийт 71 сум, байгууллагын хэвлэмэл хуудсанд зөвшөөрөл олгож 15236 ширхэг хэвлэмэл хуудасны захиалга авч хэвлүүлээ.

Аймгийн dundgovi.gov.mn сайт болон Засаг даргын Тамгын газар пэйж хуудсанд архивын үйл ажиллагаатай холбоотой 3 удаагийн мэдээлэл, Архивын ерөнхий газраас шинэчлэн баталсан Төрийн архивын үйлчилгээний үнэ тариф буюу төлбөрийн эрх зүйн актыг болон архивын лавлагааг цахимаар яаж захиалга өгөх талаарх видео бичлэгийг хийж байршуулсан.



Хяналт шалгалтын талаар:

2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын ерөнхий байцаагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нараар батлуулж, хяналт шалгалтын удирдамж боловсруулан шалгуур үзүүлэлтийн хамт холбогдох сум, байгууллагад хүргүүлсэн. Удирдамжийн дагуу 5 дугаар сард Биеийн тамир, спортын газарт хяналт шалгалт хийх байсан боловч цар тахалтай холбогдуулан түр хойшлуулаад байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг хангахад зохион байгуулалтын арга хэмжээ авах, гэрээний биелэлтийн тайлан мэдээ, дараа оны гэрээнд тусгах саналыг нэгтгэх талаар

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэх хүрээнд хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллалаа. Үүнд:

Аймгийн Засаг даргаас Цагдаагийн газрын үйл ажиллагааг дэмжин “Явуулын пост”-ыг 20.000.000 (хорин сая) төгрөгөөр, “Коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор хамгаалалтын хаалт 40 ширхэгийг 6,537.500 (зургаан сая таван зуун гучин долоон мянга таван зуу) төгрөгөөр тус тус шийдвэрлэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж хамтран ажиллалаа.



(хорин



Аймгийн ГХУСЗАЗСЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Цагдаагийн байгууллагад ISO стандарт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн 10.000.000 (арван сая) төгрөгийг үе шаттайгаар шийдвэрлэхээр тусгаж, эхний хагас жилд 2.500.000 (хоёр сая таван зуу) төгрөгийг олгоод байна.

Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойд зориулан түүхэн замналыг зурагт байдлаар багтаасан “Зурагт түүх”-ийн ном хэвлүүлэхэд нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.640.000 (Таван сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийг шийдвэрлэсэн.

Хүний эрхийн талаархи хууль тогтоомж, иргэд, байгууллагад сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь реферэнттэй хамтран иргэдэд хүний эрхийн зөрчлийн талаарх зөвлөгөө, мэдээллийг биечлэн болон Хуульчийн “Про Боно өдөр-2021” арга хэмжээний хүрээнд 05 дугаар сарын 01-ний өдөр цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулав. Тус оны эхний 5 сарын байдлаар иргэд, байгууллагаас ХЭҮК-д хандсан санал хүсэлт ирээгүй бөгөөд Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч эрүүгийн 25 хэргийн төлбөрийн чадваргүй 31 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 132 иргэнд үзүүллээ.

Хүний эрхийн аймаг дахь төлөөлөгч, Хууль зүйн туслалцааны төвийн тус аймаг дахь өмгөөлөгч нарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын өрөө, тасалгаагаар бүрэн хангаж, интернет бүхий орчинг бүрдүүлэн, урсгал зардлыг аймгийн ЗДТГ-аас бүрэн хариуцан үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНГЭЛМАА

ТАЙЛАНГ ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

Дундговь аймаг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ТУСЛАЛЦААНЫ ТАЛААРХ 2021 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН МЭДЭЭ

Д/д	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум,	Хууль, эрх зүйн хэлтэс	Бүгд
1	Хууль тогтоомжийн системчлэл мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		“Төрийн мэдээлэл” сэтгүүл болон www.legalinfo.mn сайт ашигладаг	5142	5142
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо			154	154
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		-	2	2
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл заалтын тоо		-	396	396
		Эрхзүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	97	66	163
			Байгууллага	42	128	170
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа, мэдээлэл өгсөн	Иргэд	103	39	142
			Байгууллага	98	189	287
		2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж		444
Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж бүртгүүлсэн			-	2	2
	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан			-	-	-

3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	87	6	93
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	1554	217	1771
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	139	2	141
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	28төрөл/ 2301	2 төрөл/ 600	30төрөл /2901
		ФМ, Радио, телевизийн нэвтрүүлэг	67	14	81
		Сонин хэвлэлээр сурталчилсан	10	3	13
		Бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан	166	14	180

МЭДЭЭГ ГАРГАСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЦЭНГЭЛМАА

МЭДЭЭГ ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ